

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2015 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Нэг талаас Монгол Улсын Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Онъсхон цэцэрлэг, нөгөө талаас ОХУ-ын Буриад Улсын Улаан-Үд хотын Бёрёзка цэцэрлэг нар / цаашид талууд гэх / хамтран ажиллах талаар дор дурдсан чиглэлээр харилцан тохиролцож энэхүү санамж бичгийг байгуулав.
- 1.2. Талууд сайн дурын үндсэн дээр бие биенийхээ эрх ашгийг хүндэтгэж, хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, харилцан ойлголцож энэхүү санамж бичгийг байгуулсан болно.
- 1.3. Талууд хамтын ажиллагаандаа хуулийг дээдлэх, улс хоорондын харилцааны зохистой хэм хэмжээг баримтлан, харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтална.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

- 2.1. Талууд багш, боловсон хүчний мэргэжлийн тасралтгүй хөгжлийн талаарх олон талт үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, харилцан туршлага судлах, багш солилцоог зохион байгуулах, чанар үр дүнг тооцох.
- 2.2. Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих, авъяас чадварыг хөгжүүлж буй арга туршлагаа бүтээлчээр хуваалцаж, харилцан нэгнийгээ дэмжин суралцах.
- 2.3. Хамтын ажиллагааны хүрээнд туршлага судлах, санал солилцох, зөвлөмж боловсруулах зорилгоор харилцан айлчлал хийх
- 2.4. Хамтран хийх үйл ажиллагааг бүтээлчээр хэрэгжүүлэх, харилцан хяналт үнэлгээ хийх хамтарсан ажлын хэсэг байгуулж, нэгдсэн үйл ажиллагааны хэтийн болон ойрын төлөвлөгөө боловсруулан ажиллах
- 2.5. Энэ ажлын хүрээнд хоёр орны Сургуулийн өмнөх боловсрол болон бага дунд боловсролын салбар дахь түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг бататгаж, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Хамтын ажиллагааны ерөнхий чиглэлийн хүрээнд талууд үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Талууд хоорондоо өөрийн орны боловсролын хөгжлийн талаарх мэдээ, мэдээллийг харилцан солилцох
- 3.2. Багш боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжин, харилцан туршлага солилцон, идэвхитэй суралцах

- 3.3. Багш солилцооны гэрээг байгуулж, хэрэгжүүлэн, харилцан үр дүнг тооцох
- 3.4. Боловсролын хамтын ажиллагааны түншлэлийг бэхжүүлэх урт, богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

- 4.1. Энэхүү санамж бичигт тусгасан үйл ажиллагааг талууд тус бүр хариуцаж, зохион байгуулна.
- 4.2. Санамж бичгийн хэрэгжилтийн байдлыг талуудын удирдлагууд харилцан нэгэндээ тайлагнана.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН

МОНГОЛЫН СУРГУУЛИЙН ӨМНӨХ
БОЛОВСРОЛЫН ХУВИЙН ХЭВШЛИЙН

БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНЫ



Т.МӨНХ-АЛДАР

ОХУ-ЫН БУРИАД УЛСЫН

УЛААН-ҮД ХОТЫН

“БЕРЁЗКА” ЦЭЦЭРЛЭГИЙН

ЭРХЛЭГЧ

КРИВОГОРНИЦИНА ВАЛЕНТИНА АЛЕКСАНДРОВНА

ОЛОН УЛСЫН ОЮУН УХААНЫ
МУЗЕЙН ХАРЪЯА “ОЮУНЫ ОНЬС”

СУРГУУДИЙН ЗАХИРАЛ



Т.МӨНХ-АЛДАР

ОЛОН УЛСЫН ОЮУН УХААНЫ

МУЗЕЙН ХАРЪЯА “ОНЬСХОН”

ЦЭЦЭРЛЭГИЙН ҮҮСГЭН

БАЙГУУЛАГЧ



Т.МӨНХ-АЛДАР

**ДОКУМЕНТ ПОДПИСАН
ЭЛЕКТРОННОЙ ПОДПИСЬЮ**

СВЕДЕНИЯ О СЕРТИФИКАТЕ ЭП

Сертификат 603332450510203670830559428146817986133868575813

Владелец Кривогорницына Валентина Александровна

Действителен с 16.03.2022 по 16.03.2023